

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
7 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-25
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	26-94
	1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /эцэслэн батлах/	30-34
	2.Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /эцэслэн батлах/	34-35
	3.Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /эцэслэн батлах/	35-37
	4.Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2021.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/	38-38
	5.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нарын 3 гишүүн 2020.09.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	39-40
	6.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нарын 3 гишүүн 2020.09.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/	40-42
	7.Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, хаалттай/	-
	8.“Томилгооны сонсголын журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	42-43
	9.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай	43-85
	10.Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	86-89
	11.Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/	89-89
	12.Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	89-90
	13.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	91-92
	14.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2021.06.29-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/	92-94

Хураангуй тэмдэглэл

Нэг.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ш.Ариунжаргал, Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т “Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: 1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 7

Бүгд: 52

86.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Хөдөлмөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 7

Бүгд: 52

86.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 5

Бүгд: 52

90.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 8

Бүгд: 53

84.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 8

Бүгд: 55

85.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 4

Бүгд: 55

92.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 10

Бүгд: 56

82.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 9

Бүгд: 56

83.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 8

Бүгд: 56

85.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 6

Бүгд: 56

89.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 6

Бүгд: 56

89.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 7

Бүгд: 57

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 4

Бүгд: 57

93.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 8

Бүгд: 57

86.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан:

17.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 7

Бүгд: 57

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 7

Бүгд: 57

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 9

Бүгд: 57

84.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 7

Бүгд: 57

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

21.Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 6
Бүгд: 57

89.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

22.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 5
Бүгд: 57

91.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

23.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 5
Бүгд: 57

91.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар тогтоол батлагдлаа.

Хөдөлмөрийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан 23 хууль, тогтоолын төслийг эцэслэн баталлаа.

Хууль батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлж, хууль батлахад оролцсон Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүд, Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд амжилт хүсэж, хуулийн хэрэгжилт, биелэлтэд хяналт тавьж ажиллах талаар хэлэв.

Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

;
;

;
;
;
;

;
;
;
;

;

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Нэг.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т “Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх баталснаар хуулийг эцэслэн баталсанд тооцно.” гэж заасан. Өөрөөр хэлбэл, нийт гишүүдийн олонх буюу 39-өөс дээш гишүүн хуулийн төслийг эцэслэн батална.

Хөдөлмөрийн тухай хуулийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Ингээд хамт өргөн мэдүүлсэн 16, холбогдуулан боловсруулсан 6 хууль байгаа. Нийтдээ 23 хууль батална. Эцэслэн батлах учраас бүртгэлийн санал хураалт явуулна.

Санал хураалт явуулахын өмнө төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүддээ төрсөн өдрийн баярын мэндчилгээ дэвшүүлье.

Жамбын Батсуурь гишүүн байна уу? Улсын Их Хурлын эрхэм гишүүн Жамбын Батсуурь өнөөдөр 50 нас хүрч байна. 1971 оны 7 дугаар сарын 2-ны өдөр төрсөн. Эрхэм гишүүн Жамбын Батсуурьдаа төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон танай гэр бүлийнхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Дараа нь, Улсын Их Хурлын гишүүн Лхагваагийн Мөнхбаатарын төрсөн өдөр өнөөдөр тохиож байна. 1977 оны 7 дугаар сарын 2-нд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд төрсөн. Лхагваагийн Мөнхбаатартаа төрсөн өдрийн мэнд хүргээд, бас ийм сайхан хүү төрүүлсэн ээж Цагаанлхамын Цэрэндолгорт хүү төрүүлсэн баярын мэндийг өргөн дэвшүүлье. Манай гишүүдээс дандаа аавын нэрийг дууддаг байсан, ээж нар нь бас харж байдаг, сонсож байдаг. Тэгээд ээжид нь, аавд нь, гэр бүлийнхэнд нь, Лхагваагийн Мөнхбаатар гишүүндээ төрсөн өдрийн мэнд дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Манай Мөнхбаатарын ээж Цагаанлхамын Цэрэндолгор 1955 онд төрсөн, сайхан азай буурал ээжтэй. Ээжид нь бас халуун баяр Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс дэвшүүлж байна.

Ингээд одоо санал хураалтаа явуулъя. Гишүүд төхөөрөмжөө бэлдээрэй. Бүртгэлийн санал хураалт. Бүртгэлд 13 гишүүн байхгүй байна.

Одоо санал хураалтаа эхэлье.

1.Хөдөлмөрийн тухай хуулийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Эцэслэн батлах санал хураалт

Санал хураалтад 52 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

Хөдөлмөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

45 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

51 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

6.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

7.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

8.Нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

9.Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

13.Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

14.Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

15.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

53 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

16.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томьёоллоор санал хураалт.

49 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Одоо холбогдуулан боловсруулсан:

17.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

18.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

48 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

20.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

50 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

21.Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

51 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

22.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

52 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

23.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт.

52 гишүүн дэмжиж, тогтоолын төсөл батлагдлаа.

Ингээд Хөдөлмөрийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан 23 хууль, тогтоолын төслийг эцэслэн баталлаа.

Эрхэм гишүүд ээ, энэ хууль маш чухал хууль. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах маш чухал энэ хуулийг 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилоор ахлуулсан Улсын Их Хурлын ажлын хэсэг гурван жилийн турш тасралтгүй ажиллалаа. Гурван жил энэ хуулийн төсөл дээр ажиллаж, Монгол Улсын хөдөлмөрийн харилцааны өнөөгийн байдал, үндэсний онцлог, хөдөлмөрийн зах зээлийн цаашдын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Монгол Улсын 1.1 сая ажилчид, нийт ажил олгогчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулах энэ хуулийг Улсын Их Хурал өнөөдөр эцэслэн баталж байна.

Төслийн талаар ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагуудтай зөвшилцөл, өргөн хэмжээтэй хэлэлцүүлгүүд өрнүүлсэн нь чухал ач холбогдолтой боллоо. Энэ хуулиар хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа цагаар ажиллах, гэрээсээ зайнаас ажиллах, уртын ээлжээр ажил, үүргээ гүйцэтгэх, туслах малчнаар ажиллах зэрэг хөдөлмөрийн харилцааны шинэ хэлбэрүүдээр зохицуулагдсан. Түүнчлэн ажил олгогч болон ажилтныг хөдөлмөрийн харилцаан дахь эрх, үүргийг зохистойгоор тэнцвэржүүлэх, хөдөлмөрийн гэрээний зохицуулалтыг боловсронгуй болгох, цалин хөлсийг гүйцэтгэл, бүтээмж, ур чадвартай нь уялдуулах, нарийн мэргэжлээр дагалдангаар ажиллах, дагалдангаар суралцах зэрэг нарийвчилсан

зохицуулалтуудыг тусгаснаар үндэсний ажиллах хүчний өрсөлдөх чадвар, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд энэ хууль чухал ач холбогдолтой болсныг онцлон тэмдэглэж байна.

Хуулийн төслийг Улсын Их Хуралд 2015, 2018 онд өргөн барьсан Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг, хуулийн төслийн ажлын хэсгийг ахалж ажилласан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил, Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Мөнхөөгийн Оюунчимэг, ажлын хэсэгт ажилласан Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Монголын Үйлдвэрчний эвлэлийн хороо, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын удирдлага, ажилтнууд, эрдэмтэн, судлаачдад талархал илэрхийлье. Та бүхэндээ баяр хүргэе. Сайн ажиллалаа. Түүнчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга Алимаа, ахлах шинжээч Маяа, Удирдлагын академийн профессор, доктор Уранцэцэг, Улсын Дээд шүүхийн шүүгч Тунгалаг, судлаач Батнасан нарт Улсын Их Хурлын даргын зүгээс тусгайлан баяр хүргэж байна.

Энэ хууль маань хөдөлмөрийн зах зээлд их үр дүнтэй ажиллана гэдэгт итгэж байна. Манай бас Нийгмийн бодлогын байнгын хороо, ажлын хэсэг хуулийнхаа хэрэгжилт, биелэлтэд анхаарал, хяналт тавьж ажиллахыг хүсье.

Дараагийн асуудалд орно.